ТЭНГЭРЛИГ
МЕДИА ГРУПП

ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 дүгээр сарын 04 -ний өдөр | №25/09 | Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дах заалт "Тэнгэрлиг Медиа Групп" ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 сарын 04-ны өдрийн эчнээ санал хууралтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хараат компани болох "МПЕРС" ХХК-ийн хувьцаа эзэмшигч "Ард венчурс" ХХК-ийн хувьцаа худалдах тухай саналтай танилцаж, нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000 (таван мянга) ширхэг энгийн хувьцааг Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхээс татгалзсугай.

2. "МПЕРС" ХХК-ийн хувьцаа эзэмшигч "Ард венчурс" ХХК-ийн эзэмшлийн 5,000 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг 1,000 төгрөгийн худалдах үнээр нийтэд нь 5,000,000 (таван сая) төгрөгөөр хуулийн этгээд "Хөвсгөл" ХК (РД:2034611)-д худалдахыг зөвшөөрсүгэй.

3. Дээрх өөрчлөлттэй холбоотой баримт бичигт "Тэнгэрлиг Медиа Групп" ХК-г төлөөлж гарын үсэг зурах эрхийг "Тэнгэрлиг Медиа групп" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Г.Уянга /-д олгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга /А.Хүслэн/-д даалгасугай.

ДАРГА Г.УЯНГА